



## АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/09/НА-СТА-ТТЗ

	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга:	
	Х.Түвшинбаяр	Утас: 11327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер:	
	Д.Отгонбаяр	Утас: 11315558 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarda@audit.gov.mn">otgonbayarda@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор:	
	Г.Долгорсүрэн	Утас: 11325093 Цахим хаяг: <a href="mailto:dolgorsureng@audit.gov.mn">dolgorsureng@audit.gov.mn</a>
Цахим хуудас: <a href="http://open.audit.mn">open.audit.mn</a>	Аудитор:	
Улаанбаатар хот 2024 он	Ш.Мөнхжаргал	Утас: 11325093 Цахим хаяг: <a href="mailto:munkhjargalsh@audit.gov.mn">munkhjargalsh@audit.gov.mn</a>
	Аудитор:	
	З.Мөнхзаяа	Утас: 11325093 Цахим хаяг: <a href="mailto:munkhzayaz@audit.gov.mn">munkhzayaz@audit.gov.mn</a>
	Аудитор:	
	Б.Цолмон	Утас: 11325093 Цахим хаяг: <a href="mailto:tsolmonba@audit.gov.mn">tsolmonba@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	23
4.1 Ерөнхий зүйл .....	23
4.2 Материаллаг байдал .....	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	26
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	34

### Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨУҮГ	Орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газар
ААН	Аж ахуйн нэгж
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЖДҮДТ	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв
ХААА	Худалдан авах ажиллагааны алба

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.25 № 719

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ  
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА  
Н.БАТСҮМБЭРЭЛ ТАНАА

### АУДИТЫН ДҮГНЭЛТ

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиуд шинээр батлагдаж, мөрдөж ажилласан.

Дүүргийн удирдлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус дүүргийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул дүүргийн тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

D:\Desktop\2024\Word\Recan\Бичиг\2024.03.25\10.docx  
002022227

### **Бусад асуудлын хэсэг**

Дүүргийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 6 агуулга, 84 зорилтын хүрээнд 176 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.21 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>32,025,354.7</b>	<b>37,729,571.6</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,388,390.5	27,104,068.3
33	АВЛАГА	279,700.0	303,348.6
34	УРЬДЧИЛГАА	638,558.8	2,575,245.0
35	БАРАА МАТЕРИАЛ	2,397,392.2	2,672,752.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	9,321,313.3	5,074,157.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>91,144,034.4</b>	<b>95,073,974.6</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	91,144,034.4	95,073,974.6
39200	Биет хөрөнгө	50,228,195.8	53,628,584.5
39300	Биет бус хөрөнгө	40,915,838.6	41,445,390.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>123,169,389.2</b>	<b>132,803,546.1</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>663,871.5</b>	<b>911,235.0</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	663,871.5	911,235.0
41300	Өглөг	663,871.5	911,235.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>122,505,517.6</b>	<b>131,892,311.1</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	122,505,517.6	131,892,311.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	62,267,492.3	62,267,492.3
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	40,000.0	40,000.0
51200	Хуримтлагдсан үр дүн	48,764,318.5	58,419,100.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,433,706.8	11,165,718.6
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>123,169,389.2</b>	<b>132,803,546.1</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>162,625,382.4</b>	<b>187,532,380.4</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>157,874,123.9</b>	<b>177,595,431.7</b>
110	Орлогын албан татвар	117,787,303.3	150,892,892.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	117,787,303.3	150,892,892.6
113	Хөрөнгийн албан татвар	4,279,843.0	6,324,942.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	35,806,977.6	20,377,596.5
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,872,258.4</b>	<b>8,739,277.0</b>
120	Нийтлэг татварын бус орлого	2,662,536.4	6,870,390.1
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,209,722.1	1,868,886.9
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>879,000.0</b>	<b>1,197,671.7</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>152,660,437.5</b>	<b>178,124,151.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>152,660,437.5</b>	<b>178,124,151.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>49,903,339.7</b>	<b>68,232,938.2</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,671,162.6	9,600,187.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	859,482.9	1,177,482.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,797,601.5	8,047,696.6
2104	Хангамж, бараа материалын зардал	13,068,690.6	19,412,652.1
2105	Нормативт зардал	41,315.9	40,325.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,564,133.3	4,094,976.0
2107	Томилолт, зочны зардал	330,789.3	561,282.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,968,495.1	14,464,594.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,601,668.5	10,833,740.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>102,757,097.8</b>	<b>109,891,213.1</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>9,964,944.8</b>	<b>9,408,229.1</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>95,704,418.6</b>	<b>629,813.7</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(85,739,473.7)</b>	<b>8,778,415.3</b>

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>208,895,521.3</b>	-	<b>208,895,521.3</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(640,498.9)	-	(640,498.9)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,255,022.3	-	208,255,022.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(10,031.0)	-	(10,031.0)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	(85,739,473.7)	-	(85,739,473.7)
10	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>122,505,517.6</b>	-	<b>122,505,517.6</b>
11	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>122,505,517.6</b>	-	<b>122,505,517.6</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	876,366.3	-	876,366.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,381,884.0	-	123,381,884.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(267,988.2)	-	(267,988.2)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	8,778,415.3	-	8,778,415.3
20	<b>2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>131,892,311.1</b>	-	<b>131,892,311.1</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>161,565,122.8</b>	<b>184,056,642.3</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>157,874,123.9</b>	<b>177,595,431.7</b>
110	Орлогын албан татвар	117,787,303.3	150,892,892.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	117,787,303.3	150,892,892.6
113	Хөрөнгийн албан татвар	4,279,843.0	6,324,942.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	35,806,977.6	20,377,596.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	34,134,475.6	18,247,276.6
1181	Газрын төлбөр	1,672,502.0	2,130,319.9
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,738,439.5</b>	<b>5,263,538.9</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,528,717.4	3,394,652.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,209,722.1	1,868,886.9
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>952,559.3</b>	<b>1,197,671.7</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>146,732,746.2</b>	<b>163,353,178.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>146,732,746.2</b>	<b>163,353,178.5</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,610,158.0	51,827,993.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,665,239.7	9,601,375.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	861,332.3	1,169,192.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,797,676.5	8,050,166.6
2104	Хангамж, бараа материалын зардал	12,763,711.1	14,561,295.6
2105	Нормативт зардал	41,806.9	58,350.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,846,787.9	4,273,854.0
2107	Томилолт, зочны зардал	367,513.5	566,655.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,066,219.5	9,565,128.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,199,870.7	3,981,975.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,122,588.2	111,525,185.2
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>14,832,376.6</b>	<b>20,703,463.9</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>16,252,110.2</b>	<b>12,987,786.0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>16,252,110.2</b>	<b>12,987,786.0</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	16,252,110.2	12,987,786.0
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(16,252,110.2)</b>	<b>(12,987,786.0)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(1,419,733.6)</b>	<b>7,715,677.8</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,808,124.1	19,388,390.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,388,390.5	27,104,068.3

## 2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>195,203,984.4</b>	<b>174,946,767.1</b>	<b>20,257,217.3</b>	<b>89.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>165,218,739.4</b>	<b>162,847,237.5</b>	<b>2,371,501.9</b>	<b>98.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>53,576,238.2</b>	<b>52,057,552.3</b>	<b>1,518,685.9</b>	<b>97.2</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>9,845,122.1</b>	<b>9,601,375.5</b>	<b>243,746.6</b>	<b>97.5</b>
210101	Үндсэн цалин	4,144,705.5	3,993,362.7	151,342.8	96.3
210102	Нэмэгдэл	1,074,296.5	1,041,558.6	32,737.9	97.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,290,683.8	1,211,732.6	78,951.2	93.9
210104	Урамшуулал	532,055.1	575,445.4	(43,390.3)	108.2
210105	Гэрээт ажлын хөлс	2,803,381.2	2,779,276.3	24,104.9	99.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,260,477.0</b>	<b>1,169,192.5</b>	<b>91,284.5</b>	<b>92.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	850,018.2	807,742.9	42,275.3	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	106,552.9	96,059.0	10,493.9	90.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	85,927.1	75,625.2	10,301.9	88.0
210204	Ажилгүйдлийн даатгал	23,638.6	18,878.2	4,760.4	79.9
210205	Эрүүл мэндийн даатгал	194,340.2	170,887.2	23,453.0	87.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>8,680,765.6</b>	<b>8,050,166.6</b>	<b>630,599.0</b>	<b>92.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,385,853.9	2,932,791.4	453,062.5	86.6
210302	Түлш, халаалт	3,993,285.6	3,878,024.4	115,261.2	97.1
210303	Цэвэр, бохир ус	1,267,726.1	1,208,455.8	59,270.3	95.3
210304	Байрны түрээс	33,900.0	30,895.0	3,005.0	91.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,699,602.1</b>	<b>14,556,254.1</b>	<b>143,348.0</b>	<b>99.0</b>
210401	Бичиг хэрэг	125,842.2	118,138.5	7,703.7	93.9
210402	Тээвэр, шатахуун	229,649.9	221,164.3	8,485.6	96.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	128,767.7	116,244.3	12,523.4	90.3
210404	Ном, хэвлэл	5,347.0	4,994.4	352.6	93.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,887,647.0	13,815,644.9	72,002.1	99.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	322,348.3	280,067.6	42,280.7	86.9
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>62,600.7</b>	<b>58,350.1</b>	<b>4,250.6</b>	<b>93.2</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000.0	3,184.0	1,816.1	63.7
210502	Хоол, хүнс	38,500.0	38,488.5	11.5	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,100.7	16,677.7	2,423.0	87.3
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,693,107.8</b>	<b>4,549,097.3</b>	<b>144,010.5</b>	<b>96.9</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	345,116.3	270,186.5	74,929.8	78.3
210602	Тавилга	91,123.5	57,746.5	33,377.0	63.4
210604	Урсгал засвар	4,256,868.0	4,221,164.3	35,703.7	99.2
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>604,270.0</b>	<b>565,155.4</b>	<b>39,114.6</b>	<b>93.5</b>
210701	Гадаад албан томилолт	413,270.0	399,201.8	14,068.2	96.6
210702	Дотоод албан томилолт	1,000.0	617.2	382.8	61.7
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	190,000.0	165,336.4	24,663.6	87.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,786,045.3</b>	<b>9,713,723.3</b>	<b>72,322.0</b>	<b>99.3</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,966,274.9	8,916,594.5	49,680.4	99.4
210803	Даатгалын үйлчилгээ	2,320.0	1,780.5	539.5	76.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,728.7	731.5	4,997.2	12.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	417.0	154.0	263.0	36.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	62,447.0	60,028.5	2,418.5	96.1
210807	Газрын төлбөр	748,857.7	734,434.2	14,423.5	98.1
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,944,247.6</b>	<b>3,794,237.5</b>	<b>150,010.1</b>	<b>96.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,887,027.6	3,748,205.7	138,821.9	96.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57,220.0	46,031.8	11,188.2	80.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>111,642,501.2</b>	<b>110,789,685.2</b>	<b>852,816.0</b>	<b>99.2</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>110,763,198.2</b>	<b>109,958,993.6</b>	<b>804,204.6</b>	<b>99.3</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	110,763,198.2	109,958,993.6	804,204.6	99.3
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>879,303.0</b>	<b>830,691.5</b>	<b>48,611.5</b>	<b>94.5</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8,032.7	8,032.6	0.1	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.0	292,850.0	7,150.0	97.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,920.0	9,920.0	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	72,325.0	72,237.6	87.4	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	489,025.3	447,651.3	41,374.0	91.5
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>29,985,245.0</b>	<b>12,099,529.6</b>	<b>17,885,715.4</b>	<b>40.4</b>
220001	Барилга байгууламж	13,878,054.1	2,724,621.6	11,153,432.5	19.6
223001	Бусад хөрөнгө	16,107,190.9	9,374,908.0	6,732,282.9	58.2
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>195,203,984.4</b>	<b>175,195,094.9</b>	<b>20,008,889.5</b>	<b>89.7</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,897,661.1</b>	<b>1,868,886.9</b>	<b>28,774.2</b>	<b>98.5</b>

**Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	1,897,661.1	1,868,886.9	28,774.2	98.5
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>174,091,215.2</b>	<b>172,904,642.2</b>	<b>1,186,573.0</b>	<b>99.3</b>
320001	Орон нутгийн төсвөөс	174,091,215.2	172,904,642.2	1,186,573.0	99.3
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>19,215,108.1</b>	<b>421,565.8</b>	<b>18,793,542.3</b>	<b>2.2</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	406,786.1	403,228.8	3,557.3	99.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,140.2	18,337.0	(9,196.8)	200.6
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>11</b>	<b>11</b>	-	<b>100.0</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>351</b>	<b>351</b>	-	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	15	15	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	253	253	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	78	78	-	100.0
620004	Гэрээт ажилтан	5	5	-	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>351</b>	<b>351</b>	-	<b>100.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	139	139	-	100.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	6	6	-	100.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	20	20	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	152	152	-	100.0
650010	Гэрээт ажилтан	5	5	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	29	29	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,339,821.1</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,339,821.1</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>523,475.4</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,536.0</b>
210401	Бичиг хэрэг	3,815.0
210404	Ном, хэвлэл	624.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,097.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>82,948.4</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	465.0
210602	Тавилга	17,350.0
210604	Урсгал засвар	65,133.4
<b>2107</b>	<b>Томиллот, зочны зардал</b>	<b>1,500.0</b>
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,500.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>128,337.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	126,837.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>300,154.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,154.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>816,345.7</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>735,500.0</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	720,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,500.0
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>80,845.7</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	80,845.7
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,339,821.1</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,339,821.1</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,339,669.9
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	151.2

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн эрхэм зорилгоо “Бүтээлч, оюунлаг, эрүүл иргэнтэй, амар тайван, аюулгүй орчинтой, ногоон хөгжлийг эрхэмлэсэн, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлсэн, зохистой хөдөлмөрийг дэмжсэн, хариуцлагатай, цахим систем, стандарт бүхий ухаалаг менежментийг хэрэгжүүлсэн, ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БҮХИЙ ДҮҮРЭГ болно” гэж тодорхойлсон байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр тогтоолоор Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөр нь

- Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого /6 арга хэмжээ/
- Хүний хөгжлийн бодлого /6 бүлэг, 24 арга хэмжээ/
- Эдийн засгийн бодлого /3 бүлэг, 25 арга хэмжээ/
- Засаглалын бодлого /4 бүлэг, 18 арга хэмжээ/
- Ногоон хөгжлийн бодлого /6 арга хэмжээ/
- Нийслэл ба бус, орон нутгийн хөгжлийн бодлого /6 арга хэмжээ/ -ээс бүрдсэн.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль /2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр/;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль /2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр/;
- Хөдөлмөрийн тухай хууль /2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр/;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр/

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын алба нь төлөвлөгөөний дагуу 20 байгууллагын төсвийн төлөвлөлт, төсвийн санхүүжилт, төсвийн зарцуулалт, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, түүний ашиглалт, үр ашигтай байдал, бүтэц, орон тоо цалин хөлсний тогтоолт, олголт, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэлийн байдалд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж, албан шаардлага, акт хүргүүлсэн байна.

Мөн дүүргийн Засаг даргын баталсан 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 22/06 дугаар удирдамжтай 1-19 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүд, цэцэрлэгүүд, ерөнхий боловсролын сургуулиуд, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, үнэн зөв байдалд хийсэн хяналт шалгалтаар 8 байгууллагад зөвлөмж, 4 байгууллагад албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн А/371 дүгээр захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг дүүргийн харьяа төсвийн байгууллагууд мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, төсвийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,634,156.9 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,388,390.5	27,104,068.3	7,715,677.8
АВЛАГА	279,700.0	303,348.6	23,648.6
УРЬДЧИЛГАА	638,558.8	2,575,245.0	1,936,686.2
БАРАА МАТЕРИАЛ	2,397,392.2	2,672,752.6	275,360.4
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	9,321,313.3	5,074,157.0	(4,247,156.3)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	91,144,034.4	95,073,974.6	3,929,940.2
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>123,169,389.2</b>	<b>132,803,546.1</b>	<b>9,634,156.9</b>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	663,871.5	911,235.0	247,363.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	122,505,517.7	131,892,311.1	9,386,793.4
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>123,169,389.2</b>	<b>132,803,546.1</b>	<b>9,634,156.9</b>

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бусад эргэлтийн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцооны данснууд байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 27,104,068.3 мянган төгрөг болж өмнөх оноос 7,715,677.8 мянган төгрөгөөр буюу 39.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>16,192,565.7</b>	<b>21,288,132.6</b>	<b>5,095,566.9</b>
<b>Төгрөг</b>	<b>16,192,565.7</b>	<b>21,288,132.6</b>	<b>5,095,566.9</b>
Төрийн сангийн харилцах	16,192,155.0	21,288,120.4	5,095,965.4
Арилжааны банк дахь харилцах	410.7	12.2	(398.5)
<b>Замд яваа мөнгөн хөрөнгө</b>	<b>3,195,824.8</b>	<b>5,815,935.7</b>	<b>2,620,110.9</b>
<b>Дүн</b>	<b>19,388,390.5</b>	<b>27,104,068.3</b>	<b>7,715,677.8</b>

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансанд 21,288,120.4 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан нь ОНХС-ийн 948,514.5 мянга, дүүргийн хөрөнгө оруулалтын барьцаа 502,893.3 мянга, орон нутгийн ерөнхий орлогын дансны 19,836,712.6 мянган төгрөгөөс тус тус бүрдэж байна.

Арилжааны банкны “0” үлдэгдэлтэй төсвийн орлогын харилцах данснаас гүйлгээ хаагдсаны дараа татварын 5,815,935.7 мянган төгрөгийн орлого дүүргийн төрийн сангийн орлогын ерөнхий дансанд 2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр он дамжиж орсон тул замд яваа мөнгөн хөрөнгөөр тайлагнажээ.

**Аудитын илрүүлэлт:**

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 102,478.4 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан /ЗДТГ 67,220.0 мянга, ИТХ 6,418.4 мянга, Соёлын төв 20,940.0 мянга, ХОББДТ 7,900.0 мянган төгрөг, Хүүхэд хөгжлийн цогцолбор/
- ААН-тэй бараа, ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцолгүйгээр санхүүжилт бүрэн олгосон. /ЗДТГ/
- Тайлант онд 12,273.6 мянган төгрөгийн нөхөн олговрыг төсвөөс төлсөн, дүүргийн дотоод аудитын алба гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ аваагүй. /ЗДТГ/

**3.4.2 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 303,348.6 мянган төгрөг болж өмнөх оноос 23,648.6 мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	248.9	248.9
Дансны авлага /ТӨҮГ/	2,500.0	2,500.0	-
Байгууллагаас авах авлага	273,988.4	296,065.0	22,076.6
Хувь хүмүүсээс авах авлага	3,211.6	4,534.8	1,323.2
<b>Дүн</b>	<b>279,700.0</b>	<b>303,348.6</b>	<b>23,648.6</b>

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдлийн 89.0 хувь буюу 270,000.0 мянган төгрөг нь Асати Монгол ХХК-иас авах авлага эзэлж байна. Мөн нийт авлагын 93.6 хувь буюу 283,848.8 мянган төгрөгийн авлага нь он удаан жил болсон авлагууд байна. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 270,000.0 мянга, ЗДТГ 11,159.7 мянга, Хоймор хайрхан ОНӨААН 2,500.0 мянга, Нийтлэг үйлчилгээний газар 189.1 мянган төгрөг/

**Аудитын илрүүлэлт:**

- Санхүүгийн тайланд тусгасан 29,744.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, бүртгэсэн огноо, эзэн холбогдогчийг олж, барагдуулах арга хэмжээ аваагүй. /ЗДТГ/
- Санхүүгийн тайланд тусгасан 270,854.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 270,668.9 мянга, ОНХС 186.0 мянган төгрөг/

**3.4.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны үлдэгдэл 2,575,245.0 мянган төгрөг болж өмнөх оноос 1,936,686.2 мянган төгрөгөөр буюу 3.0 дахин өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	638,558.8	2,575,245.0	1,936,686.2
<b>Дүн</b>	<b>638,558.8</b>	<b>2,575,245.0</b>	<b>1,936,686.2</b>

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 2,549,183.8 мянга, ОНХС-ийн 4,145.6 мянга, ЗДТГ-ын 21,912.8 мянга, ХОББДТ 2.8 мянга, нийт 2,575,245.0 мянган төгрөгийн урьдчилгаа бүртгэсэн байна. Урьдчилгаа дансны 99.1 хувь буюу 2,553,329.4 мянган төгрөгийг ОНХС, дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаас бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн санхүүжилт эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн тайланд тусгасан 25,958.4 мянган төгрөгийн урьдчилгаа дансны үлдэгдэлд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй. /ЗДТГ 21,812.8 мянга, ОНХС 4,145.6 мянган төгрөг/
- Санхүүгийн байдлын тайланд ААН-д олгосон урьдчилж төлсөн зардлын 1,924,621.6 мянган төгрөгийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэснийг аудитын явцад залруулсан. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/
- Дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаар иргэд, хүүхэд залуучууд, ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заал барих /Баян могод ХХК-д олгосон 552,247.1 мянган төгрөг/, авто замын хөдөлгөөний хяналтын камер суурилуулах /Мөлүү хээр" ХХК-д олгосон 60,315.1 мянган төгрөг/, зураг төсвийн ажил хийлгэх /Аркосис ХХК-д олгосон 80,136.5 мянган төгрөг/ ажлууд нь гэрээний хугацаа дууссан боловч ажил бүрэн хийгдээгүй. /Дүүргийн төсвийн төвлөрүүлэн захирагч/

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 2,672,752.6 мянган төгрөг болж өмнөх оноос 275,360.4 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>3,589.0</b>	<b>394,209.9</b>	<b>390,620.9</b>
Тусгай зориулалттай материал	-	391,139.8	391,139.8
Эм боох материал	3,589.0	3,070.1	(518.9)
<b>Хангамжийн материал</b>	<b>2,393,803.2</b>	<b>2,278,542.7</b>	<b>(115,260.5)</b>
Бичиг хэргийн материал	35,449.4	31,222.6	(4,226.8)
Аж ахуйн материал	166,905.8	169,397.1	2,491.3
Сэлбэг хэрэгсэл	16,419.0	31,051.3	14,632.3
Түлш, шатах тослох материал	14,096.4	22,827.0	8,730.6
Барилгын засварын материал	221,247.5	160,698.9	(60,548.6)
Хүнсний материал	1,311.6	8,127.9	6,816.3
Бусад хангамжийн материал	1,938,373.5	1,855,217.9	(83,155.6)
<b>Дүн</b>	<b>2,397,392.2</b>	<b>2,672,752.6</b>	<b>275,360.4</b>

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материалын данс нь худалдан авсан 3,869,323.6 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 404,714.8 мянга, нийт 4,274,038.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 3,436,878.9 мянга, акталсан болон байгууллага хооронд шилжүүлсэн 561,799.1 мянга, нийт 3,998,678.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны нэмэгдсэн дүнгийн 41.0 хувь, буурсан дүнгийн 39.8 хувийг дүүргийн хөрөнгө оруулалтын зардлын данснаас хийсэн хөрөнгө оруулалтын ажлын хөдөлгөөн эзэлж байна. Мөн тайлант онд дүүргийн ЗДТГ нь байгууллагын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/402 дугаар тушаалаар 524,189.5 мянган төгрөгийн 569 нэр төрлийн 28,736 нэгж бараа материалыг акталж, данс бүртгэлээс хассан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Нийт 70,180.5 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй, олгосон шатахуун талоны дүнгээр зарлагдсан. /ЗДТГ/
- 2022 онд хөрөнгө оруулалтын зардлаас хийгдсэн нөөцийн бараа дансанд бүртгэсэн 80,136.5 мянган төгрөгийн ажлыг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй, хөрөнгө оруулалтын ажлыг дуусгах арга хэмжээ аваагүй. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/
- Нөөцийн бараа дансанд 2021-2020 онуудад хийгдэж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэсэн бөгөөд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй, 208,087.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан. /Орон нутгийн хөгжлийн сан/

**3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө**

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 5,074,157.0 мянган төгрөг болж өмнөх оноос 4,247,156.3 мянган төгрөгөөр буюу 45.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	9,321,313.3	5,074,157.0	(4,247,156.3)
<b>Дүн</b>	<b>9,321,313.3</b>	<b>5,074,157.0</b>	<b>(4,247,156.3)</b>

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэхүү дансанд дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн, ашиглагч байгууллага хүлээн аваагүй, холбогдох байгууллагын шийдвэр гараагүй хөрөнгийг бүртгэдэг. Уг дансанд дүүргийн хөрөнгө оруулалтын 4,866,069.2 мянга, ОНХС-ийн 208,087.8 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэсэн байна.

**3.4.6 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 95,073,974.6 мянган төгрөг болж өмнөх оноос 3,929,940.2 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	44,563,738.9	40,496,072.9	(4,067,666.0)
Авто-тээврийн хэрэгсэл	764,809.3	2,770,638.9	2,005,829.6
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,397,514.4	4,080,638.3	1,683,123.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	645,027.1	589,071.2	(55,955.9)
Бусад үндсэн хөрөнгө	1,714,763.5	5,544,826.4	3,830,062.8
Ном	142,342.5	147,336.9	4,994.4
<b>Биет хөрөнгийн дүн</b>	<b>50,228,195.7</b>	<b>53,628,584.6</b>	<b>3,400,388.8</b>
Програм хангамж	17,254.1	313,122.0	295,867.9
Бусад биет бус хөрөнгө	40,898,584.6	41,132,268.0	233,683.5
<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>40,915,838.7</b>	<b>41,445,390.0</b>	<b>529,551.4</b>
<b>Дүн</b>	<b>91,144,034.4</b>	<b>95,073,974.6</b>	<b>3,929,940.2</b>

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн худалдан авалтаар 610,885.0 мянга, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 23,160,259.3 мянга, нийт 23,771,144.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталсан 2,068,238.2 мянга, байгууллага хооронд шилжүүлсэн 13,270,929.6 мянга, нийт 15,339,167.8 мянган төгрөгийн хөрөнгөөр буурсан байна. Тайлант онд 6,932,547.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Тайлант онд Нийслэлийн ИТХ-ын тогтоол болон бусад баримт бичгийг үндэслэн дүүргийн ЗДТГ-аас Хайрхан хөгжлийн төв ОНӨААТҮГ-т 105 нэр төрлийн 659 нэгж 6,789,383.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлсэн, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын тушаалаар 9,168,723.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж устгасан зэрэг томоохон дүнтэй гүйлгээ хийгдсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоог бодож акт үйлдээгүй, тооллогын комиссын санал болгосон асуудлыг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлээгүй, албан хаагчдын эд хөрөнгийн бүртгэл дээрх хөрөнгийн дүн санхүүгийн байдлын тайлан дахь дүнгээс зөрсөн, бүртгэлтэй хөрөнгийг бүрэн эзэнжүүлээгүй. /ЖДҮДТ 6,535.3 мянга, Хүүхэд хөгжлийн цогцолбор 25,915.1 мянган төгрөг/
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогод 65,966.8 мянган төгрөгийн бараа материалыг хамруулаагүй. /ЖДҮДТ 62,636.8 мянга, Хүүхэд хөгжлийн цогцолбор 3,330.0 мянган төгрөг/
- НББ-д бүртгэлтэй байсан барилга, байгууламжийг ашиглагч байгууллагад шилжүүлэхдээ 34,528,133.5 мянган төгрөгийн уг барилга, байгууламжид хамаарах газрыг бүртгэлээс хасаж, балансаас балансад шилжүүлээгүй. /ЗДТГ/
- Үндсэн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй, тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн. /Нийтлэг үйлчилгээний газар/
- Иргэн Б.Тогтмолын эзэмшиж байгаа газрын төлбөр 7,673.3 мянган төгрөгийг төсвөөс төлсөн газар, барилга байгууламж бусад хөрөнгийг шилжүүлэн бүртгээгүй. /Хоймор хайрхан ОНӨААТҮГ/

**3.4.7 Өр төлбөр**

Өр төлбөр дансны үлдэгдэл 911,235.0 мянган төгрөг болж өмнөх оноос 247,363.5 мянган төгрөгөөр буюу 37.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 8. Өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
<b>Өглөг</b>	<b>519,626.5</b>	<b>660,154.1</b>	<b>140,527.6</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	3,365.1	7,720.8	4,355.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	516,261.4	652,433.3	136,171.9
<b>Бусад өглөг</b>	<b>144,245.0</b>	<b>251,080.9</b>	<b>106,835.9</b>
Байгууллагад төлөх өглөг	138,314.7	244,929.1	106,614.4
Хувь хүмүүст төлөх өглөг	-	221.5	221.5
Татварын өглөг /ТӨҮГ/	2,987.1	2,987.1	-
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	2,943.2	2,943.2	-
<b>Дүн</b>	<b>663,871.5</b>	<b>911,235.0</b>	<b>247,363.5</b>

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 911,235.0 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнаснаас 758,544.7 мянган төгрөг буюу 83.2 хувийг хөрөнгө оруулалтын ажлын барьцаа эзэлж байна. Мөн үйл ажиллагаа явуулаагүй Чингэлтэйн дүүргийн Ахмадын амралт, сувилал ОНӨУҮГ-тай холбоотой 5,930.3

мянган төгрөгийн татвар, НДШ-ийн өглөг тайлагнасан байна. Нийт өр төлбөрийн 10.1 хувь буюу 92,448.3 мянган төгрөгийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл нэмэгдэхэд хөрөнгө оруулалтын ажил өмнөх онуудаас өссөнтэй холбоотойгоор барьцаа 148,070.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн, дүүргийн ИТХ-ын өр төлбөрийн үлдэгдэл 74,192.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Санхүүгийн тайланд тусгасан 92,448.3 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 37,607.2 мянга, ОНХС 17,500.7 мянга, Нийтлэг үйлчилгээний газар 12,405.7 мянга, ЗДТГ 24,934.7 мянган төгрөг/
- 2019 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан барьцааны хугацаа дууссан 10,428.9 мянган төгрөгийн барьцааг орон нутгийн төсвийн орлогын ерөнхий дансанд төвлөрүүлээгүй. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/

**3.4.8 Засгийн газрын оролцоо**

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 131,892,311.1 мянган төгрөг болж өмнөх оноос 9,386,793.4 мянган төгрөгөөр буюу 7.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Засгийн газрын оруулсан капитал</b>	<b>62,267,492.3</b>	<b>62,267,492.3</b>	-
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	62,267,492.3	62,267,492.3	-
<b>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</b>	<b>40,000.0</b>	<b>40,000.0</b>	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>48,764,318.6</b>	<b>58,419,100.2</b>	<b>9,654,781.6</b>
Өмнөх үеийн үр дүн	48,764,318.6	49,640,684.9	876,366.3
Тайлант үеийн үр дүн		8,778,415.3	8,778,415.3
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>11,433,706.8</b>	<b>11,165,718.6</b>	(267,988.2)
<b>Дүн</b>	<b>122,505,517.7</b>	<b>131,892,311.1</b>	<b>9,386,793.4</b>

Эх сурвалж: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 131,892,311.1 мянган төгрөг болж 9,386,793.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Дүүргийн ТТЗ-ийн 2023 оны төсвийн төсөлд дүүргийн орон нутгийн төсвийн эх үүсвэрийг 186,599,214.6 мянган төгрөгөөр, нийслэлд төвлөрүүлэх орлогын хэмжээг 115,740,453.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн байгууллагуудын урсгал зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 49,594,552.8 мянган төгрөгөөр, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 19,245,477.1 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг 2,018,731.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг дүүргийн ИТХ-аар хэвээр баталсан байна.

### 3.5.2 Дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлт

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ-ын “Дүүргийн 2023 оны төсөв батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 15-ны 28 дугаар тогтоолоор анх төсвийн орлогыг 171,049,657.5 мянга, өөрийн орлогыг 581,501.3 мянга, урд оны үлдэгдлээс 13,476,028.7 мянга, ОНХС-ийн санхүүжилтийг 1,492,027.1 мянга, нийт 186,599,214.6 мянган төгрөгөөр үүнээс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлого 115,740,453.5 мянга, төсвийн нийт зарлагыг 70,858,761.1 мянган төгрөгөөр төсвийг ашиг, алдагдалгүй байхаар баталжээ.

Төсөвт өөрчлөлт оруулан дүүргийн ИТХ-ын “Дүүргийн төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 16 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 174,091,215.2 мянга, өөрийн орлогыг 415,926.3 мянга, урд оны үлдэгдлээс 18,799,181.8 мянга, ОНХС-ийн санхүүжилтийг 1,897,661.1 мянга, нийт 195,203,984.4 мянган төгрөгөөр үүнээс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлого 108,268,833.0 мянга, төсвийн нийт зарлагыг 86,935,151.4 мянган төгрөгөөр төсвийг ашиг, алдагдалгүй байхаар баталжээ.

Тайлант онд 174,507,141.5 мянган төгрөгийг дүүргийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 180,628,884.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 103.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 10. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
<b>УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>174,507,141.5</b>	<b>180,628,884.6</b>	<b>6,121,743.1</b>	<b>103.5</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>172,415,896.4</b>	<b>177,595,431.7</b>	<b>5,179,535.3</b>	<b>103.0</b>
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>141,443,978.3</b>	<b>150,892,892.6</b>	<b>9,448,914.3</b>	<b>106.7</b>
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	93,999,257.7	113,391,719.2	19,392,461.5	120.6
Үйл ажиллагааны орлого	2,275,424.6	1,664,794.5	(610,630.1)	73.2
Иргэдийн хадгаламжийн хүүгийн татварын орлого	26,944,273.0	14,284,622.1	(12,659,650.9)	53.0
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	4,293,187.0	3,195,393.6	(1,097,793.4)	74.4
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын орлого	13,931,836.0	18,356,363.1	4,424,527.1	131.8
<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>4,809,071.0</b>	<b>6,324,942.6</b>	<b>1,515,871.6</b>	<b>131.5</b>
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	4,752,771.0	6,288,759.1	1,535,988.1	132.3
Галт зэвсгийн албан татвар	56,300.0	36,183.5	(20,116.5)	64.3
<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>26,162,847.1</b>	<b>20,377,596.5</b>	<b>(5,785,250.6)</b>	<b>77.9</b>
Улсын тэмдэгтийн хураамж	21,731,761.0	16,787,887.9	(4,943,873.1)	77.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,446,055.0	1,459,388.7	(986,666.3)	59.7
Газрын төлбөр	1,985,031.1	2,130,319.9	145,288.8	107.3
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,091,245.1</b>	<b>3,033,452.8</b>	<b>942,207.7</b>	<b>145.1</b>
Хүү, торгуулийн орлого	1,675,318.8	2,605,740.4	930,421.6	155.5
Төсөв байгууллагын өөрийн орлого	415,926.3	421,565.8	5,639.5	101.4
Ангилалдаагүй бусад орлого	-	6,146.6	6,146.6	

Төлөвлөгөө тасарсан орлогууд: иргэдийн хадгаламжийн хүүгийн татварын орлого, улсын тэмдэгтийн хураамж, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, хог хаягдлын үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны орлого, галт зэвсгийн албан татвар

**Иргэдийн хадгаламжийн хүүгийн татвар:** Тайлант онд 26,944,273.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 14,284,622.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 53.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Тухайн төрлийн татварын орлого нь арилжааны банкнуудад хугацаатай

хадгаламжийн данстай иргэдийн орлогоос хамаарч төвлөрдөг бөгөөд өмнөх онуудтай харьцуулахад хадгаламжийн орлого буурсантай холбоотой байна.

**Улсын тэмдэгтийн хураамж:** Тайлант онд 21,731,761.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 16,787,887.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 77.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Уг төрлийн орлого нь төрийн холбогдох байгууллагаас зөвшөөрөл олгосны дагуу төсөвт төвлөрдөг орлого тул тайлангаар ногдсон татварын дутуу үлдэгдэлгүй, сард тогтмол төлөх орлогын дүнд хяналт тавих боломж бага мөн урьд онтой харьцуулахад шүүхийн шийдвэрээр буцаан олгох захирамжийн дүн урьд оноос 2 дахин өссөн, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас төвлөрөх улсын тэмдэгтийн хураамжийн орлого 2023 оны 02 дугаар сараас нийслэлийн Хан-Уул дүүрэг рүү шилжсэнтэй зэргээс шалтгаалан төсвийн орлого тасарсан байна.

**Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого:** Тайлант онд 4,293,187.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 3,195,393.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 74.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус татварын төрөл нь татварын албанаас үл хамааран хөрөнгийн зах зээлд үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөн, төгрөгийн ханш буурсан зэрэг нь иргэдийн дунд үл хөдлөх хөрөнгө борлуулах нь багассантай холбоотойгоор тасарсан байна.

**Хог хаягдлын үйлчилгээний хураамж:** Тайлант онд 26,944,273.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 14,284,622.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 59.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/492 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтад “Хог хаягдлын олон нийтийн байцаагчийг хөлсөөр ажиллуулах гэрээг Дүүргийн ЗДТГ байгуулна.” гэж заасан. Одоогоор дүүргийн ЗДТГ-ын орон тооны бүтцэд 24 хороонд томилсон хог хаягдлын олон нийтийн байцаагч байхгүй нь төлөвлөгөө тасрах шалтгаан болсон байна.

**Үйл ажиллагааны орлого:** Тайлант онд 2,275,424.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 1,664,794.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 73.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Галт зэвсгийн албан татвар:** Тайлант онд 56,300.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 36,183.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 64.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Галт зэвсгийн албан татварын орлогын төлөвлөгөөг сар бүр жигд ханган биелүүлэхээр Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтран бүртгэл тооллогын мэдээллийг авах, тулгах, үүний үр дүнд олон жил хуримтлагдсан өрийг хамтран барагдуулж ажиллахаар төлөвлөгөө гарган алба бичиг хүргүүлсэн, сар бүр галт зэвсгийн албан татварын өртэй татвар төлөгчид мэдээлэл хүргүүлэх масс мессеж болон имэйлийг тогтмол хүргүүлэн ажилласан боловч тогтсон тарифаараа бааз нь нэмэгдээгүй шалтгаанаар орлого тасарсан байна.

### 3.5.3 Дүүргийн төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 8,604,769.8 мянга төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрийн 41 арга хэмжээг санхүүжүүлэхээр 174,091,215.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,897,661.1 мянган төгрөгийн улсын төсвөөс, 18,799,181.8 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 415,926.3 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 172,904,642.2 мянган төгрөг, улсын төсвөөс 1,868,886.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 421,565.8 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна. Нийслэлд төвлөрүүлэх орлогыг 108,268,833.0 мянган төгрөгөөр төлөвлөснийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 174,946,767.1 мянга төгрөг буюу 89.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 2,371,501.9 мянга, хөрөнгийн зардлыг 17,885,715.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 11. Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

	/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>195,203,984.4</b>	<b>174,946,767.1</b>	<b>20,257,217.3</b>	<b>89.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>165,218,739.4</b>	<b>162,847,237.5</b>	<b>2,371,501.9</b>	<b>98.6</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>53,576,238.2</b>	<b>52,057,552.3</b>	<b>1,518,685.9</b>	<b>97.2</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,845,122.1	9,601,375.5	243,746.6	97.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,260,477.0	1,169,192.5	91,284.5	92.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,680,765.6	8,050,166.6	630,599.0	92.7
Хангамж, бараа материалын зардал	14,699,602.1	14,556,254.1	143,348.0	99.0
Нормативт зардал	62,600.7	58,350.1	4,250.6	93.2
Эд хогшил, урсгал засварын зардал	4,693,107.8	4,549,097.3	144,010.5	96.9
Томилолт, зочны зардал	604,270.0	565,155.4	39,114.6	93.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,786,045.3	9,713,723.3	72,322.0	99.3
Бараа үйлчилгээний бусад зардал	3,944,247.6	3,794,237.5	150,010.1	96.2
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>111,642,501.2</b>	<b>110,789,685.2</b>	<b>852,816.0</b>	<b>99.2</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>29,985,245.0</b>	<b>12,099,529.6</b>	<b>17,885,715.4</b>	<b>40.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 1,339,821.1 мянган төгрөг орж ирснийг хангамж, бараа материалын зардалд 10,536.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 82,948.4 мянга, томилолтын зардалд 1,500.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 128,337.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 300,154.0 мянга, хэлмэгсдэд олгосон цагаатгалын нөхөн олговорт 720,000.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 15,500.0 мянга, нийт 1,258,975.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 80,845.7 мянган төгрөгийг Нийслэл дэх төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.6.5 Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ-ын “Дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 16 дугаар тогтоолоор он дамжсан 47 төсөл, арга хэмжээний нийт 12,441,988.7 мянга, 2023 онд хэрэгжих 33 төсөл, арга хэмжээний 17,543,256.3 мянга, нийт 29,985,245.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталжээ.

Хөрөнгө оруулалтын тухайн онд санхүүжих 33 төсөл, арга хэмжээнд нийт 17,543,256.3 мянган төгрөгийн санхүүжилт, он дамжин хэрэгжих 47 төсөл арга хэмжээний 12,441,988.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд нийт 12,304,078.2 мянга, техник хяналтын зардал, зохиогчийн хяналт, магадалшгүй ажил 86,390.1 мянга,

барьцаа дансанд 279,964.5 мянга, нийт 12,304,078.2 мянган төгрөгийг гүйцэтгэлээр санхүүжүүлж, үлдэгдэлгүй тайлагнасан байна.

### **ОНХС-гийн хөрөнгө оруулалт:**

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ-ын “Дүүргийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 16 дугаар тогтоолоор он дамжсан 11 төсөл, арга хэмжээний нийт 522,974.0 мянга, 2023 онд хэрэгжих 32 төсөл, арга хэмжээний 1,901,391.2 мянга, нийт 2,424,365.2 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр нийслэлийн ОНХС-аас 1,868,886.8 мянга, урьд оны үлдэгдэл 526,704.1 мянган төгрөгийн орлого орсноос гүйцэтгэгч байгууллагад 1,620,160.6 мянга, барьцаа дансанд 84,586.4 мянга, техник хяналтын зардалд 72,328.8 мянга, нийт 1,620,160.6 мянган төгрөгийг олгож, 837,014.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан.

**Нийт барьцаа хөрөнгө:** Дүүргийн барьцаа хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 527,213.2 мянган төгрөг байснаас 364,551.0 мянган төгрөгийн барьцааг нэмж байршуулж, 277,371.4 мянган төгрөгийн барьцааг чөлөөлж, оны эцэст 614,392.8 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

### **3.6.6 ОНӨААН-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ, Хайрхан хөгжлийн төв ОНӨТҮГ, Хоймор хайрхан амралт, сувилал ОНӨТҮГ, Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ гэсэн 4 ААН-ийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ОНӨААН-үүд нь 2023 онд 18,456,151.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 7,806,207.0 мянган төгрөгийг зарцуулж, 10,649,944.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан боловч нийт орлогын 1.9 хувийг байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болгосон байна.

Дүүргийн Засаг дарга орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг батлах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, гүйцэтгэсэн ажлын үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж байх, дотоод хяналтыг сайжруулах, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, шатахууны тооцоог холбогдох заавар журмын дагуу тооцож байх, хөрөнгийн ангиллыг үнэн зөв бүртгэх, он удаан жил болсон авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн ахлах аудитор Г.Долгорсүрэн, аудитор Ш.Мөнхжаргал, З.Мөнхзаяа, Б.Цолмон нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг дарга дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/467 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 248,364,856.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,725,472.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүн өмнөх оноос 69,610,016.0 мянган төгрөгөөр буурсан тул материаллаг байдлын түвшин 1,044,150.2 мянган төгрөгөөр буурсан.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын хэрэгжилтийг шалгахад цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмжийг бусад этгээдээс худалдан авсан, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэж, нөөцөлсөн зэрэг нийт 108,955.8 мянган төгрөгийн 6 зөрчил илэрсэн.

Шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэж нөөцөлсөн бараа материалаа нийт дүнгээр нь орлого авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" заалтыг зөрчсөн байна. /ИТХ 3,364.0 мянган төгрөг/

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд намын суудлын мөнгө олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 "Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна." заалтуудтай нийцэхгүй байна. /ИТХ 35,000.0 мянган төгрөг/

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Нийт 70,591.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан аваагүй, харьцуулалтын арга хэрэглээгүй, хөрөнгө худалдан авах гэрээ байгуулаагүй, хөрөнгө хүлээн авсан акт үйлдээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." заалтыг зөрчсөн. /ЗДТГ 70,591.8 мянган төгрөг/

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Тайлант онд сургалт семинар, хурал зөвлөгөөнийг танхимаар зохион байгуулсан, зардал хэмнэх арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;" заалтыг хэрэгжүүлээгүй. /ЗДТГ/

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж Чингэлтэй дүүргийн цахим хуудсаар өдөр тутам сурталчилсан мэдээллийг сурталчлуулахаар 59,950.0 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.4 Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" заалттай нийцэхгүй байна. /ЗДТГ/

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Цасны баяр, сургалт, онцгой комиссын гишүүдийн хувцас зэрэгт 31.1 сая төгрөгийн төсөв үрэлгэн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтуудыг зөрчиж байна. /ЗДТГ/

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамаарах 5 шалгагдагч байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллээс 833,237.2 мянган төгрөгийн 6 мэдээллийг ил тод байршуулаагүй, 529,981.1 мянган төгрөгийн 36 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.1 *“Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”* заалттай тус тус нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна. /ЗДТГ 497,151.1 мянган төгрөгийн 15 гүйлгээ, ИТХ 32,830.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 833,237.2 мянган төгрөгийн 6 гүйлгээ, Нийтлэг үйлчилгээний газар 15 мэдээлэл, ХОББДТ 3 мэдээлэл/

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй шалгагдагч 5 байгууллагад дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай зарим талаар нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Тайлант онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдөөгүй, сонгон шалгаруулалт зарлалгүйгээр шууд гэрээ байгуулж бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 *“Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно.”*, 8.1.1 *“харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;”* 8.1.2 *“шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;”* 8.2 *“Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.”*, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан *“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”*-ийг зөрчсөн. /ЗДТГ/

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 6,213,622.3 мянган төгрөгийн 31 алдаа, зөрчил илэрснээс дүүргийн төсвийн хөрөнгөөр 2018, 2019 онуудад хийлгэсэн биет бус хөрөнгүүд нь ашигладаггүй, сайжруулалт хийгдээгүй 160,033.2 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрлээгүй, НББ-д барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж зэрэг ерөнхий нэрээр бүртгэсэн 888,580.0 мянган төгрөгийн хөрөнгийг НББ-д бүртгэсэн зөрчлүүдийг арилгаагүй, завсрын аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 4,24,380.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 82,264.7 мянган төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 2,853,557.6 мянган төгрөгийн зөрчилд 14 албан шаардлага, 2,036,558.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 58 зөвлөмж өгч, 270,000.0 мянган төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлсэн.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	5	82,264.7	5	82,264.7	100.0
Албан шаардлага	14	1,853,557.6	4	913,359.5	71.4
Зөвлөмж	58	2,036,558.5	49	1,628,523.8	84.5
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	1	270,000.0			-
<b>Нийт дүн</b>	<b>78</b>	<b>4,242,380.8</b>	<b>58</b>	<b>2,624,148.0</b>	<b>85.3</b>

Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлөөс мөнгөн хөрөнгө, бараа материал зарлагадахдаа бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан, ажлын гүйцэтгэл үр дүн харгалзаагүй, байгуулсан гэрээг дүгнэлгүйгээр санхүүжилт олгосон, авлага, өр төлбөрийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй, хөрөнгө оруулалтын зардлаас ААН-д олгосон урьдчилгааг барагдуулаагүй, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил давтан илэрсэн, өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйд зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дүүргийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15-ны 29 дүгээр тогтоолоор Чингэлтэй ахмадын амралт ОНӨААТҮГ, Чингэлтэй дүүргийн Ахмадын амралт, сувилал ОНӨУҮГ-ыг Хоймор хайрхан амралт, сувилал ОНӨТҮГ-тай нэгтгэж, хөрөнгийг шилжүүлэх, тус 2 байгууллагын үйл ажиллагааг дуусгавар болгох тогтоол гарсан боловч 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Чингэлтэй ахмадын амралт ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд 227,141.3 мянга, Чингэлтэй дүүргийн Ахмадын амралт, сувилал ОНӨУҮГ-ын санхүүгийн тайланд 542,387.0 мянга, нийт 769,528.3 мянган төгрөгийн хөрөнгө тайлагнасан хэвээр байгааг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 11 төсвийн байгууллага, сан, зардал, 4 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 17 байгууллага, сан, зардал аудитад хамрагдсан. Үүнд: Орон нутгийн төсвийн 7 байгууллага /ИТХ, ЗДТГ, ЖДҮДТ, ХААА, Дотоод аудитын алба, Хүүхэд хөгжлийн цогцолбор, Соёлын төв/, 4 сан, зардал /Нийгмийн халамж, асрамж үйлчилгээний зардал, Тохижилт үйлчилгээний зардал, ОНХС, Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/, 4 ОНӨААН /Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ, Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжлийн төв ОНӨТҮГ, Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ, Чингэлтэй дүүргийн Хоймор хайрхан амралт, сувилал ОНӨТҮГ/ -ын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	НТАГ-аас дүгнэлт гаргасан	Аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	2		9	
2	ОНӨААН	1		3	
	<b>Дүн</b>	<b>3</b>		<b>12</b>	

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” /ИТХ, ЗДТГ, Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ/ дүгнэлт өгсөн.

### 5.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аудитаар нийт 3,313,080.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Аудитаар нийт 1,623,690.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 10,428.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 754,807.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 858,454.2 мянган төгрөгийн 39 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 3,313,080.0 мянган төгрөгийн 17 алдаа илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд бараа материал акталсан зардал, үндсэн хөрөнгө шилжүүлсний гарзыг 456,515.0 мянган төгрөгөөр дутуу /ЗДТГ/, өмнөх үеийн үр дүнг 111,798.5 мянган төгрөгөөр илүү /ЗДТГ/, үндсэн хөрөнгө худалдсаны гарзыг 2,614.6 мянган төгрөгөөр дутуу /ЖДҮДТ/, элэгдлийн зардлыг 1,020.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. /Хүүхэд хөгжлийн цогцолбор/
- Мөнгөн гүйлгээний тайланд нийт цэвэр мөнгөн гүйлгээг 34,802.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. /ХОББДТ/
- Санхүүгийн байдлын тайланд ААН-д олгосон урьдчилж төлсөн зардлыг 1,924,621.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/
- Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлант үеийн үр дүнг 17,546.2 мянган төгрөгөөр дутуу /ИТХ/, өмнөх оны нийт үр дүнг 135,119.2 мянган төгрөгөөр дутуу /ХОББДТ 99,010.4

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мянга, Хоймор хайрхан ОНӨААТҮГ 36,108.8 мянган төгрөг/, зарлагын дүнг 398.4 мянган төгрөгөөр илүү /Хоймор хайрхан ОНӨААТҮГ/ тайлагнасан.

- Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд бараа үйлчилгээний бусад зардлыг 4,500.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. /ЗДТГ/
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг 750.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. /Хүүхэд хөгжлийн цогцолбор 300.0, Соёлын төв 450.0 мянган төгрөг/, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 585,605.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. /Орон нутгийн хөгжлийн сан/
- Үндсэн үйл ажиллагааны 2,890.0 мянган төгрөгийн орлогыг мөнгөн сууриар бүртгэсэн. /Соёлын төв/
- Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд бараа материалын эцсийн үлдэгдлийг 1,198.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн. /Соёлын төв/
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлого 33,699.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/

### **5.1.1 Орон нутгийн байгууллага**

Аудитаар нийт 1,593,711.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 10,428.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 754,807.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 828,475.2 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 28 зөвлөмжийг холбогдох шалгагдагч байгууллагад тус тус хүргүүлсэн.

#### **Төлбөрийн акт**

1. 2019 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан барьцааны хугацаа дууссан 10,428.9 мянган төгрөгийн барьцааг орон нутгийн төсвийн орлогын ерөнхий дансанд төвлөрүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" заалтыг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/

#### **Албан шаардлага**

2. Санхүүгийн тайланд тусгасан 60,108.6 мянган төгрөгийн авлага, өр төлбөрийн үлдэгдэлд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалттай нийцээгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал 38,276.2 мянга, ОНХС 21,832.4 мянган төгрөг/

### **5.1.2 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд**

Аудитаар нийт 29,979.0 мянган төгрөгийн зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх 11 зөвлөмжийг холбогдох шалгагдагч байгууллагад тус тус хүргүүлсэн.

### **5.2 ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Дүүргийн хөрөнгө оруулалтын зардлаар иргэд, хүүхэд залуучууд, ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заал барих /Баян могод ХХК-д олгосон 552,247.1 мянган төгрөг/, авто замын хөдөлгөөний хяналтын камер суурилуулах /Мөлүү хээр" ХХК-д олгосон 60,315.1 мянган төгрөг/, зураг төсвийн ажил хийлгэх /Аркосис ХХК-д олгосон 80,136.5 мянган

*төгрөг/ ажлууд нь гэрээний хугацаа дууссан боловч ажил бүрэн хийгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг зөрчсөн, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн. /Дүүргийн төсвийн төвлөрүүлэн захирагч/*

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

Нийт хөрөнгө оруулалтын зардлын 24.5 хувь буюу 2,049,058.2 мянган төгрөгийг тусдаа төсөвтэй, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх төсвийн ерөнхийлөн захирагчтай байгууллагуудын санхүүгийн хэрэгцээг хангахад зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар 5.1.2."төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2."төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 6.6.6."тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" заалтыг хэрэгжүүлээгүй байна. /Дүүргийн төсвийн төвлөрүүлэн захирагч/

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг дүүргийн төсвөөс санхүүжүүлэхгүй байх, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлж байх зөвлөмж өгсөн.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт-1:* Нийт 220 албан хаагчид ажлын үр дүн, ажилласан жил зэрэг үзүүлэлтийг харгалзалгүйгээр 220.0 сая төгрөгийн дэмжлэг хавтгайруулан олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг хэрэгжүүлээгүй байна. /ЗДТГ/

*Илрүүлэлт-2:* 2023 оны 12 дугаар сард улсын төсвөөс санхүүждэг ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг өрхийн эрүүл мэндийн төвийн дарга зэрэг нийт 113 хүнийг БНХАУ-д томилолтоор ажиллуулахаар шийдвэр гаргаж 102,150.1 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг хэрэгжүүлээгүй байна. /ЗДТГ/

*Илрүүлэлт-3:* Нийт 38,456.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг шууд зардалд бүртгэсэн /судалгааны ажил хийлгэх ямар хэрэгцээ байгаа цаашид хэрхэн, юунд ашиглах талаар судалгаа хийгээгүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтуудыг зөрчсөн байна. /ЗДТГ/

*Илрүүлэлт-4:* Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар 102,478.4 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй

байх;" заалтыг зөрчсөн байна. /ЗДТГ 67,220.0 мянга, ИТХ 6,418.4 мянга, Соёлын төв 20,940.0 мянга, ХОББДТ 7,900.0 мянган төгрөг, Хүүхэд хөгжлийн цогцолбор/

*Илрүүлэлт-5:* Аж ахуйн нэгжтэй бараа, ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцолгүйгээр санхүүжилт бүрэн олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;", 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх"; 5.1.3. "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" 5.1.5 "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтуудыг хэрэгжүүлээгүй. /ЗДТГ/

*Илрүүлэлт-6:* Тайлант онд 12,273.6 мянган төгрөгийн нөхөн олговрыг төсвөөс төлсөн, дүүргийн дотоод аудитын алба гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ аваагүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.", 103.3 "Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна." заалтыг зөрчсөн байна. /ЗДТГ/

*Илрүүлэлт-7:* Нийслэлийн авто баазаас машин түрээсэлсэн 2,266.1 мянган төгрөгийн зардлыг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын холбогдох заалтыг зөрчсөн байна. /ИТХ/

*Илрүүлэлт-8:* Тайлант онд төсвийн хөрөнгөөр хийгдсэн видео шторк, контентын 19,400.0 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн нь Зар сурталчилгааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 "Зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгч зар сурталчилгаатай холбоотой баримт болон тэдгээрийн хуулбарыг тухайн зар сурталчилгааг сүүлчийн удаа түгээснээс хойш 6 сараас доошгүй хугацаагаар хадгална." заалтыг зөрчсөн байна. /Соёлын төв/

*Илрүүлэлт-9:* Хувь хүний орлогын албан татварын тайланд цалингийн сангийн дүнг 5,345.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4.үнэн зөв байх;" Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар 2 дугаар зүйлийн 2.1.4 "Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх" заалтыг зөрчсөн байна. /Соёлын төв/

#### Өгсөн зөвлөмж:

- Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;
- Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийхгүй байх, гүйцэтгэсэн ажлын үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж байх;
- Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх заалтыг мөрдөж ажиллах;
- Санхүүгийн тайланд зардлын ангилал зөв тайлагнах, холбогдох тайлан мэдээг зөв тайлагнаж байх;

## **2. Авлага, урьдчилгаа, өр төлбөртэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт-1:* Санхүүгийн тайланд тусгасан авлага, урьдчилгаа, өр төлбөрийн нийт 88,998.0 мянган төгрөгийн үлдэгдэлд тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, бүртгэсэн огноо, эзэн холбогдогчийг олж, барагдуулах арга хэмжээ аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны НТАГ-2024/09/НА-СТА-ТТЗ

тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг зөрчсөн байна. /ЗДТГ 76,592.3 мянга, Нийтлэг үйлчилгээний газар 12,405.7 мянган төгрөг/

*Илрүүлэлт-2:* ХХОАТ-ын 684.8 мянган төгрөгийн дутуу төлөлтийг /ЖДҮДТ/, 100.0 мянган төгрөгийн илүү төлөлтийг /Хүүхэд хөгжлийн цогцолбор/ санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:**

- Санхүүгийн тайланд тусгасан авлага, урьдчилгаа, өр төлбөрийн хариуцах эзэн холбогдогчийг олж, барагдуулах арга хэмжээ авах;
- Харилцагч байгууллагуудтай үүссэн авлага, өр төлбөрийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

**3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт-1:* Элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй 21,186,070.8 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалттай нийцэхгүй байна. /ЗДТГ/

*Илрүүлэлт-2:* Жилийн эцсийн хөрөнгийн тооллогод 65,966.8 мянган төгрөгийн бараа материалыг хамруулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/" /ЖДҮДТ 62,636.8 мянга, Хүүхэд хөгжлийн цогцолбор 3,330.0 мянган төгрөг/

*Илрүүлэлт-3:* Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоог бодож акт үйлдээгүй, тооллогын комиссын санал болгосон асуудлыг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлээгүй, албан хаагчдын эд хөрөнгийн бүртгэл дээрх хөрөнгийн дүн санхүүгийн байдлын тайлан дахь дүнгээс зөрсөн, бүртгэлтэй хөрөнгийг бүрэн эзэнжүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 "Тооллогын комисс дараахь үүрэгтэй: 1/ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" заалтуудыг зөрчсөн байна. /ЖДҮДТ 6,535.3 мянга, Хүүхэд хөгжлийн цогцолбор 25,915.1 мянган төгрөг/

*Илрүүлэлт-4:* Газрыг байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4.үнэн зөв байх;" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. /ЖДҮДТ, Хүүхэд хөгжлийн цогцолбор/

*Илрүүлэлт-5:* Хөрөнгийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн дүн, тооцоо бодсон дүнгээс 19,806.4 мянган төгрөгөөр зөрсөн, бараа материалын 12 дугаар сарын тайлан гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4.үнэн зөв байх;" Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар 2 дугаар зүйлийн 2.1.4

"Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх" заалтыг зөрчсөн байна. /Соёлын төв/

*Илрүүлэлт-6:* Үндсэн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй, тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,"; 12 дугаар зүйлийн 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72, 73 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. /Нийтлэг үйлчилгээний газар/

*Илрүүлэлт-7:* Барилга, авто машины хувийн хэрэг хөтлөөгүй, тайлант онд гарсан өөрчлөлтийг хувийн хэрэгт тусгаагүй нь Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалаар баталсан Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмыг хэрэгжүүлээгүй байна. /Нийтлэг үйлчилгээний газар, ХОББДТ/

*Илрүүлэлт-8:* Ажил үйлчилгээтэй холбоотой гэрээ байгуулсан боловч гэрээг дүгнээгүй, нийтийн эзэмшилд хийгдсэн ажил, бараа үйлчилгээг хүлээн авахдаа ажил хүлээлцсэн акт үйлдэн бараа материалын дансаар дамжуулан зарлагадсан, хөрөнгийг холбогдох байгууллагуудад хандаж данс бүртгэлд тусгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. /ХОББДТ/

*Илрүүлэлт-9:* Амралтын газрыг эзэмшиж буй байгууллага нь бүртгэлд аваагүй, кадастрын зураг хийгдээгүй, хувийн хэрэг хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. /Хоймор хайрхан ОНӨААТҮГ, Хайрхан хөгжлийн төв ОНӨААТҮГ/

*Илрүүлэлт-10:* Иргэн Б.Тогтмолын эзэмшиж байгаа газрын төлбөр 7,673.3 мянган төгрөгийг төсвөөс төлсөн газар, барилга байгууламж бусад хөрөнгийг шилжүүлэн бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтуудыг зөрчсөн байна. /Хоймор хайрхан ОНӨААТҮГ/

*Илрүүлэлт-11:* Цайны газрын түрээсийн гэрээг Сүүж уулын оргил ХХК-тай хийсэн боловч түрээсийн гэрээг дүгнээгүй, сарын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлүүлдэггүй, нийт 2,000.0 мянган төгрөгийн авлагыг тооцоогүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. /Хайрхан хөгжлийн төв ОНӨААТҮГ/

#### Өгсөн зөвлөмж:

- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгөд дахин үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

- Хөрөнгийн тооллогыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, тооллогын комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулах, эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах;
- Үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх;
- Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, гүйцэтгэсэн ажлын үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж байх, дотоод хяналтыг сайжруулах;
- Данс бүртгэлд тусгасан түрээсийн авлагын тооцоог холбогдох хууль тогтоомжийн дагуу тушаал шийдвэрийг үндэслэж шийдвэрлэх, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах.

#### 4. Бараа материалын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт-1:* Нийт 70,180.5 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй, олгосон шатахуун талоны дүнгээр зарлагадсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалтыг хэрэгжүүлээгүй байна. /ЗДТГ/

*Илрүүлэлт-2:* 2022 онд хөрөнгө оруулалтын зардлаас хийгдсэн 80,136.5 мянган төгрөгийн ажлыг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй, хөрөнгө оруулалтын ажлыг дуусгах арга хэмжээ аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг зөрчсөн байна. /Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/

*Илрүүлэлт-3:* Нөөцийн бараа дансанд 2021-2020 онуудад хийгдэж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэсэн бөгөөд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй, 208,087.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтуудыг зөрчсөн байна. /Орон нутгийн хөгжлийн сан/

*Илрүүлэлт-4:* Бараа материалыг бөөн дүнгээр, нэршил тодорхойгүй, тоо хэмжээ, хэмжих нэгж алдаатай бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "5.1.3 жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4 үнэн зөв байх" заалттай нийцэхгүй байна. /Нийтлэг үйлчилгээний газар/

#### Өгсөн зөвлөмж:

- Төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, шатахууны тооцоог холбогдох заавар журмын дагуу тооцож байх;
- Хөрөнгө оруулалтын ажлыг гэрээт хугацаанд нь дуусгаж, гэрээний хэрэгжилтийг дүгнэж байх;
- Нөөцийн бараа дансанд бүртгэсэн өмнөх онуудад хийгдэж дууссан ажлуудыг ашиглагч байгууллагуудад шилжүүлэх, нөөцийн бараа дансны үлдэгдлийг цэгцлэх;
- Хөрөнгийн нэр төрөл, марк, хэмжих нэгж, тоо хэмжээг тодорхой бүртгэх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2024 оны 8 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				
								Үүнээс		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		
	<b>Чингэлтэй дүүргийн ТТЗ</b>											
1	Чингэлтэй дүүргийн ИТХ	1	17,546.2			1	17,546.2	1	17,546.2			
2	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	3	572,813.5			3	572,813.5	3	572,813.5			
3	Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалтын зардал	2	1,958,321.1			2	1,958,321.1	2	1,958,321.1			
4	Чингэлтэй дүүргийн ЖДҮДТ	1	2,614.6			1	2,614.6	1	2,614.6			
5	Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж, асрамж үйлчилгээний зардал											
6	Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээний зардал											
7	Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын алба											
8	Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба											
9	Чингэлтэй дүүргийн Соёлын төв	3	4,538.7			3	4,538.7	3	4,538.7			
10	Чингэлтэй дүүргийн Хүүхэд хөгжлийн цогцолбор	2	1,320.4			2	1,320.4	2	1,320.4			
11	Чингэлтэй дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан	1	585,605.4			1	585,605.4	1	585,605.4			
	<b>Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн</b>	<b>13</b>	<b>3,142,759.9</b>			<b>13</b>	<b>3,142,759.9</b>	<b>13</b>	<b>3,142,759.9</b>			
12	Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв	2	133,813.3			2	133,813.3	2	133,813.3			
13	Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжлийн төв											
14	Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар											
15	Чингэлтэй дүүргийн Хоймор хайрхан амралт, сувилал	2	36,507.2			2	36,507.2	2	36,507.2			
	<b>ОНӨААН-ийн дүн</b>	<b>4</b>	<b>170,320.5</b>			<b>4</b>	<b>170,320.5</b>	<b>4</b>	<b>170,320.5</b>			
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>17</b>	<b>3,313,080.4</b>			<b>17</b>	<b>3,313,080.4</b>	<b>17</b>	<b>3,313,080.4</b>			

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	<b>Чингэлтэй дүүргийн ТТЗ</b>	2	694,698.6			1	694,698.6	1					
1	Чингэлтэй дүүргийн ИТХ	3	8,684.5					3	8,684.5				
2	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	9	366,872.5					9	366,872.5				
3	Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалтын зардал	3	128,841.6	1	10,428.9	1	38,276.2	1	80,136.5				
4	Чингэлтэй дүүргийн ЖДҮДТ	4	69,856.9					4	69,856.9				
5	Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж, асрамж үйлчилгээний зардал												
6	Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээний зардал												
7	Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын алба												
8	Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба												
9	Чингэлтэй дүүргийн Соёлын төв	4	65,492.0					4	65,492.0				
10	Чингэлтэй дүүргийн Хүүхэд хөгжлийн цогцолбор	5	29,345.1					5	29,345.1				
11	Чингэлтэй дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан	2	229,920.1			1	21,832.4	1	208,087.7				
	<b>Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн</b>	<b>32</b>	<b>1,593,711.3</b>	<b>1</b>	<b>10,428.9</b>	<b>3</b>	<b>754,807.2</b>	<b>28</b>	<b>828,475.2</b>				
12	Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв	3	7,900.0					3	7,900.0				
13	Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжлийн төв	2	2,000.0					2	2,000.0				
14	Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар	5	12,405.7					5	12,405.7				
15	Чингэлтэй дүүргийн Хоймор хайрхан амралт, сувилал	1	7,673.3					1	7,673.3				
	<b>ОНӨААН-ийн дүн</b>	<b>11</b>	<b>29,979.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>11</b>	<b>29,979.0</b>				
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>43</b>	<b>1,623,690.3</b>	<b>1</b>	<b>10,428.9</b>	<b>3</b>	<b>754,807.2</b>	<b>39</b>	<b>858,454.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	<b>Чингэлтэй дүүргийн ТТЗ</b>								
1	Чингэлтэй дүүргийн ИТХ	3	71,194.0			1	3,364.0	2	67,830.0
2	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	6	567,742.9					6	567,742.9
3	Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалтын зардал	1	833,237.2					1	833,237.2
4	Чингэлтэй дүүргийн ЖДҮДТ								
5	Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж, асрамж үйлчилгээний зардал								
6	Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээний зардал								
7	Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын алба								
8	Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба								
9	Чингэлтэй дүүргийн Соёлын төв								
10	Чингэлтэй дүүргийн Хүүхэд хөгжлийн цогцолбор								
11	Чингэлтэй дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан								
	<b>Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн</b>	10	1,472,174.1			1	3,364.0	9	1,468,810.1
12	Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв	1						1	
13	Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжлийн төв								
14	Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар	1						1	
15	Чингэлтэй дүүргийн Хоймор хайрхан амралт, сувилал								
	<b>ОНӨААН-ийн дүн</b>	2						2	
	<b>НИЙТ ДҮН</b>	12	1,472,174.1			1	3,364.0	11	1,468,810.1